



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 400

Улаанбаатар хот

“Бизнесийн оргил” ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг  
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Бизнесийн оргил" ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тус ХЗХ-ны гишүүдийн хадгаламж, зээлийн үлдэгдэл, төлбөр тооцоог барагдуулахыг “Бизнесийн оргил” ХЗХ /Ж.Болормаа/-нд үүрэг болгосугай.

3. "Бизнесийн оргил" ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийлгэхийг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-д тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

001062